



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Номгон

Хог хаягдал ангилан ялгах ажлыг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.6, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.2, 10.2.6, 10.2.8, 10.2.12, 10.2.14, 10.2.16, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1, Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.6, 6.1.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2, 5.2.10, 5.3.1, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.2, 6.1.5, 6.1.12 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрийн нийт айл өрх, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, зах, худалдааны төв, хүнсний дэлгүүр, бар, ресторан, иргэд стандартын шаардлага хангасан хог хаягдлын сав байршуулах, хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгаж, ачиж тээвэрлэх ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж явуулсугай.

2.Хог хаягдал ачиж тээвэрлэх хуваарийг нэгдүгээр, ангилан ялгах хогийн савны стандартыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Ангилан ялгасан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг “Цэвэр хот” ОНӨААТҮГазрын дарга (Ц.Баясгалан), иргэн, байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулж хог хаягдлыг ангилан ялгах мэдлэг, боловсрол олгохыг төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, багийн Засаг дарга нарт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллахыг сумын Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, мэргэжилтэн нарт тус тус үүрэг болгосугай.

4.Хог хаягдлын стандартын шаардлага хангасан сав байршуулж, ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулж, хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгасан

Захирамж 2023 он


601010793

тухай тайланг сар бүрийн 30-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлж, ирсэн тайланг нэгтгэн сумын Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүн (Б.Ганшүүдэр)-д даалгасугай.

5.Ажлын явц, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчилж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Г.Сувданцэцэг), орон нутгийн телевизэд үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР




Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны  
...01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02  
дугаар захирамжийн ...1... дүгээр хавсралт

ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ХУВААРЬ


№	Багийн нэр	Тээвэрийн хэрэгслийн жолоочийн нэр, утасны дугаар	Тээвэрийн хэрэгслийн дугаар	Ачилт хийх он сар өдөр
1	2	3	4	5
1	Номгон баг 1 дүгээр баг	Жолооч Д.Очирбат 88750478	52-32 БНХ	1, 3, 5, 6, 7 дахь өдөр
2	Эрдэнэмандал 2 дугаар баг	Жолооч Б.Батнасан 88441128	07-32 БНХ	Сар бүрийн 1-нээс 15-ныг хүртэл
3	Дуурсах 3 дугаар баг	Жолооч Ц.Тогоохүү 88320012	31-46 БНХ	Сар бүрийн 1-нээс 15-ныг хүртэл
4	Угалз 4 дүгээр баг	Жолооч Д.Даваадорж 88139984	00-43 БНР	Сар бүрийн 1-нээс 15-ныг хүртэл
5	Цагаанчулуут 5 дугаар баг	Жолооч З.Доржхорол 99959744	37-96 БНХ	Сар бүрийн 1-нээс 15-ныг хүртэл
6	Гэгээншавь 6 дугаар баг	Жолооч Д.Бямбаа 80680868	40-89 БНХ	Сар бүрийн 15-наас 30-ныг хүртэл
7	Цахир 7 дугаар баг	Жолооч Ц.Мөнхбаяр 88460182	31-76 БНХ	Сар бүрийн 15-наас 30-ныг хүртэл
8	Есөнбулаг 9 дүгээр баг	Жолооч Г.Билэгт 88441821	32-64 БНХ	Сар бүрийн 15-наас 30-ныг хүртэл
9	Рашаант 10 дугаар баг	Жолооч Ц.Мөнхсуурь 80500063	41-15 БНХ	1, 3, 5, 6, 7 дахь өдөр

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны  
...01 дүгээр сарын 02 ны өдрийн 4/02  
захирамжийн хавсралт



### АНГИЛАН ЯЛГАХ ХОГИЙН САВНЫ СТАНДАРТ ХЭМЖЭЭ

1.50-60 айлын орон сууцны гадна тавигдах хог ангилан ялгах сав



2. Спортын ордон, барааны захуудад тавигдах хог ангилан ялгах сав



3. Төрийн болон сургууль, цэцэрлэг, коллеж, худалдааны төвүүдийн гадна тавигдах хогийн сав

